

БАТЛАВ

“БЗӨБЦТС” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.ТАВИНБЭХ

..... оны сарынөдөр

**Эмнэлгийн анхны тусламжийн иж бүрдэл нийлүүлэх гүйцэтгэгчийг
сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг**

Тендер шалгаруулалтын дугаар: ХАН№19/15

БЗӨБЦТС ТӨХК 2019 он

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Үнэлгээний хорооны дарга

Х.Төгсжаргал /ХАБЭАА-ны дарга/

Үнэлгээний хорооны нарийн бичиг

Д.Мягмарсүрэн /Гэрээний мэргэжилтэн/

Гишүүдэд :

Х.Хандмаа /Цалин хөлс хариуцсан ня-бо/

Б.Туяа /Хөндлөнгийн гишүүн /

Ц.Энхбат /Хөндлөнгийн гишүүн/

Тендер шалгаруулалтын нэр:

Эмнэлгийн анхны тусламжийн иж
бүрдэл нийлүүлэх гүйцэтгэгчийг
сонгон шалгаруулах тендерийн
баримт бичиг

Тендер шалгаруулалтын дугаар:

ХАН№19/15

Хаяг:

Улаанбаатар хот Багануур дүүрэг
үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС”
ТӨХК-ний конторын байр

Утас:

99020551

Факс:

70210167

ХАН№19/15 тоот тендерийн урилга

Эмнэлгийн анхны тусламжийн иж бүрдэл нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцохыг урьж байна.

Тендерийн баримт бичгийн дагуу холбогдох материалуудыг бүрдүүлж Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр илгээж бидэнтэй хамтран ажиллахыг хүсье. Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn сайтаас /Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем/ татаж үзнэ үү.

Хаяг :

Улаанбаатар хот Багануур дүүрэг
үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ний
конторын байр 202 тоот өрөө.

Утас: 99020551

Факс: 70210167

Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг цахимаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Санал болгож буй материалыг үнийн саналын маягтын дагуу ирүүлэх;
 - (б) Нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) ТООЗ 1.1 дэх заалтын дагуу бусад материалыг бэлтгэж ирүүлэх.
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
 - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТООЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт /Бүрдүүлэх материал/
ТООЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар 2. Үнийн санал /маягтын дагуу/ 3. 2018 оны аудитлагдсан санхүүгийн тайлан ирүүлэх 4. НӨАТ төлөгч бол гэрчилгээний хуулбар, НӨАТ биш бол энэ тухай албан бичиг ирүүлэх 5. Сүүлийн хоёр /2017-2018 он/ жилийн борлуулалтын орлого тендерийн төсөвт өртгөөс багагүй байна. /Сангийн сайдын 2013 оны тушаалын хавсралт “Цахим тендер зохион байгуулах журмын 1.2 дахь заалтын дагуу цахим тендерийн лавлагааг үндэслэнэ/ 6. Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд шүүхийн ямар нэгэн зарга маргаангүй талаарх тодорхойлолт. /Шүүхийн төрөлжсөн архив, ШШГЕГ-аас тус тус ирүүлэх/ 7. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх /Татварын тодорхойлолтыг www.tender.gov.mn цахим сайтын тендерийн лавлагааг үндэслэнэ/ 8. Нийлүүлэх бараа материалын техникийн тодорхойлолтыг ирүүлэх /Захиалагчийн техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан байх/ 9. Тендерт оролцогч нь ГТН 4-р заалтыг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлэх. 10. Нийлүүлэх хугацаа нь гэрээ байгуулсанаас хойш 21 хоногоос ихгүй, хүргэх газар Багануур дүүргийн үйлдвэрийн хэсгийн “БЗӨБЦТС” ТӨХК-ийн агуулахад 11. Одоо хэрэгжүүлж буй бараа материал нийлүүлж байгаа гэрээний жагсаалтыг маягтын дагуу ирүүлэх. 12. Сүүлийн 3 жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт гэрээ, гэрээ дүгнэсэн акт тэдгээрийн ажлын өртөг, хугацаа байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт ирүүлэх./2016-2018 онуудын аль нэгэнд/. 13. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлж байсан нь тендерээс татгалзах үндэслэл болно. <p>Дээрх баримт бичгийг бүрдүүлж ирээгүй тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.1.3 дугаар зүйлийн шаардлагыг хангаагүй гэж үзэн ирүүлсэн тендерээс татгалзана.</p>
ТООЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.</p> <p>Огноо: Тендерийг 2019 оны 08 дугаар сарын 07-ний өдрийн 13 цаг 00 минутаас өмнө цахим системээр илгээх.</p>
ТООЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Нээлтийг 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 13 цаг 30 минутаас цахим системээр нээнэ.</p> <p>УБ хот Багануур дүүрэг 3-р хороо үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ийн өөрийн байр, 2-р давхар 202 тоот өрөө 99020551</p>
ТООЗ 7.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий байна:</p> <p>ХАН№19/15 “Эмнэлгийн анхны тусламжийн иж бүрдэл нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг” Багцтай эсэх: Үгүй</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТОО ХЭМЖЭЭ

Д/д	Нэр, төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /ширхэг/	Техникийн үзүүлэлт
1	Эмнэлгийн анхны тусламжийн иж бүрдэл	ком	10	<p><u>Иж бүрдэлд:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Денутрат спирт 15гр 2. Иодын ханд 15гр 3. Ариун резинэн бээлий 4. Халуун хэмжигч 5. Хурууны лент 6. Балын харандаа 7. Тэмдэглэлийн дэвтэр 8. Сүлбээрэн зүү 9. Мохоо хайч 10. Шархны лент /2x40/ 11. Сунадаг боолт /6см өргөнтэй/ 12. Сунадаг боолт /8см өргөнтэй/ 13. Сунадаг боолт /12см өргөнтэй/ 14. Даралттай ариун боолт 15. Ариун бинт /7x14/ 16. Хөвөн /50 гр/ 17. Ариун жийргэвч /5x5см/ 18. Ариун жийргэвч /10x10см/ 19. Ариун жийргэвч /20x20см/ 20. Гурвалжин алчуур /150x150x80см/ 21. Чих цэвэрлэгч /100ш-тэй/ 22. Шингэн сэлбэх давс /27.9 гр/ 23. Гарын саван 24. Иж бүрдлийн цүнх (хайрцаг) <p><u>Тоо хэмжээ:</u></p>
2	Эмнэлгийн анхны тусламжийн эмийн сангийн баяжилт	ком	120	<p><u>Иж бүрдэлд:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Валидол 2. Долоогоны ханд 3. Тамединий уусмал <p><u>Тоо хэмжээ:</u></p>

				<ul style="list-style-type: none"> 4. Наштырын спирт /50 мл 1ш 5. Адреналин /1амп/ 1ш 6. Өвчин намдаах эм 3 боодол 7. Боодлын мароль 1ш 8. Боодлын хөвөн 1ш 9. Хурууны лент 30ш 10. Ариутгасан резин бээлий 1 хос 11. Шархны лент 1ш 12. Шингэн сэлбэх давс 2ш
3	Хор саармагжуулах бүтээгдэхүүн	ш	1992	<ul style="list-style-type: none"> - Аарц, сүү, шүлтлэг рашаан, эрүүл мэндийн ундаа зэрэг хор саармагжуулах үйлчилгээ бүхий шингэн хүнсний бүтээгдэхүүн байх - Хэмжээ 250 граммаас багагүй байх - Бүтээгдэхүүний агууламжинд Витамин С - 100-150мг, А – 2мг, В₁ - 3-4 мг В₆ - 2мг, В₁₂ - 2мг, РР - 15мг-аас багагүй хэмжээтэй орсон байх - Нийлүүлэх бүтээгдэхүүн нь Монгол Улсын эрүүл ахуйн стандартын шаардлага, холбогдох хууль тогтоомжийн дагуу баталгаажсан байх - Битүүмжлэгдсэн савлагаатай, лацтай байх - Үйлдвэрлэсэн болон хадгалах, дуусах хугацаа бичигдсэн байх - Хадгалах хугацаа дуусаагүй, лабораторийн шинжилгээний бичигтэй байх
4	Эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх витаминжуулалт	ш	510	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ бүхий витамин, витаминжуулсан ундаа, байгалийн гаралтай жимс жимсгэний 100 хувь органик цэвэр шүүс (шингэн бол хэмжээ 125мл-ээс багагүй байх), - Нийлүүлэх бүтээгдэхүүн нь Монгол Улсын эрүүл ахуйн стандартын шаардлага, холбогдох хууль тогтоомжийн дагуу баталгаажсан байх - Битүүмжлэгдсэн савлагаатай, лацтай байх - Үйлдвэрлэсэн болон хадгалах, дуусах хугацаа бичигдсэн байх - Хадгалах хугацаа дуусаагүй, лабораторийн шинжилгээний бичигтэй байх
5	Цусны сахар хэмжих аппарат	ш	1	<ul style="list-style-type: none"> - Цусан дахь сахар хэмжигч аппарат - Хэмжих хязгаар: 1,1mmol/L-33,3mmol/L - Батарейгаар ажиллах боломжтой. - 250 хэмжилтийг санах багтаамжтай - 15 сек - 3 минутын хооронд автоматаар унтардаг - 8 секундэд хэмжилтийг хийх <p>Дагалдах хэрэгсэл:</p>

				<ul style="list-style-type: none"> - Аппаратны тест 100 ширхэгээс багагүй байх - Тусгай хатгуур ба түүнд хэрэглэгдэх нэг удаагийн зүү 100 ширхэгээс багагүй байх - Аппаратыг хадгалах хатуу гэртэй байх
6	Даралтны аппарат	ш	1	<ul style="list-style-type: none"> - Цусны даралт болон зүрхний цохилтыг хэмждэг бүрэн автомат даралт хэмжигчтэй - Зүрхний хэм алдагдалтыг илрүүлдэг. - Даралтны аппаратан гэрлэн заагчтай - Ашиглахад хялбар, LCD дэлгэцтэй. - Он, сар, өдөр нь автоматаар таардаг. - Автоматаар өөрөө унтрах тохиргоотой - Ажиллуулах явцад алдаа гарвал дохио өгөх - Батарей дуусахыг заадаг. - Аппаратыг хадгалах хатуу гэртэй.
ДҮН				

Тайлбар: Ажлын шаардлагаар 6,227,260 төгрөгийн эм, эмийн бүтээгдэхүүнийг худалдан авсан болно. Иймд уг тендерийн төсөвт өртгөөс 6,227,260 төгрөгийг хасч үнийн саналаа ирүүлнэ үү.

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

БЗӨБЦТС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Н.Тавинбэх танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу ажлын [санал болгож буй нийлүүлэх хугацааг бичнэ] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Техникийн тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|---|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Нийлүүлэхээр санал болгож буй журнал болон гэрээний дэвтэрийг захиалагчийн томилсон ажлын хэсэг хүлээн авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо үйлдвэрийн хэсэг БЗӨБЦТС ТӨХК-ийн агуулахад |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 (нэг) жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг 2019 оны 12 дугаар сард барагдуулна. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1 Нийлүүлэхээр санал болгож буй журнал болон гэрээний дэвтэрийг захиалагчийн томилсон ажлын хэсэг хүлээн авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь; |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.] |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | Урьдчилгаа санхүүжилт олгохгүй. Гэрээний төлбөрийг гэрээ дүгнэсэн акт болон нийлүүлэгчийн нэхэмжлэхийг үндэслэн 2019 оны 12 дугаар сард барагдуулна.
. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | 9.1. Алданги оногдуулах хувь: Нэг өдрийн 0,5%

Алдангийн нийт дүн: Гэрээний нийт үнийн дүнгийн 10% |